



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 17/12

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит бус XVI хуралдааны 2019 оны 16/05
дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XVI хуралдааны 2019 оны 16/05 дугаар тогтоолоор Супрессор өрхийн Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2005 онд ашиглалтад орсон 2018 оны дахин үнэлгээгээр 27 624 272,87 төгрөгөөр үнэлэгдсэн өрхийн эмнэлэгийн барилгын худалдах доод үнийг 25,0 сая төгрөгөөр тогтоож дуудлагын худалдаагаар худалдах шийдвэр гарсан.

Уг барилгын дуудлагын худалдааг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй, цаашид өрхийн эмнэлгийн барилгын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор барилгыг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтарч “Утаагүй–Баянхонгор” төслийг хэрэгжүүлж ард иргэдэд сургалт сурталчилгаа хийх Инновацийн загвар төв байгуулан ашиглах шаардлагатай байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 25 дугаар зүйлийн 25.4 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XVII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын Супрессор өрхийн Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, хашааг газрын хамт Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт Инновацийн загвар төвийн зориулалтаар балансаас балансад үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.


2. Барилга, хашаа, газрыг комисс томилж актаар хүлээлгэн өгч, шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу бүртгэж, биелэлтийг 2019 оны 10 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/- д үүрэг болгосугай.

1190033

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус ХҮI хуралдааны 16/05 дугаар тогтоолын нэг дэх заалтаас “Супрессор өрхийн эмнэлэгийн барилгын худалдах доод үнийг 25,0 сая төгрөгөөр тогтоож худалдах” гэсэн хэсгийг хүчингүй болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР